



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/15

Хужирт сум

Албан тушаалын тодорхойлолт
шинэчлэн батлах тухай

Соёлын сайдын 2020 оны “Албан тушаалын жишиг тодорхойлолт батлах тухай” А/75 дугаар тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Соёлын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын төвийн дарга (О.Долгормаа), хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/90 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ